


ЖЕНКО ТУР БЮРО ХК (JTB.MSE)

Салбар: Аялал жуулчлал

2012.09.11

Хувьцааны үнэ



Үнэт цаасны үзүүлэлтүүд

Симбол	JTB
Хувьцааны код	521
Нийт гаргасан хувьцаа	100,000,000
Зах зээлийн үнэ 2012.09.11	92
Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	9.2
52 долоо хоног- их/бага (төгрөг)	88 / 114

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

	2010	2011
Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	11.81	8.79
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)	0.10	0.25
Өр төлбөрийн дүн (тэрбум төгрөг)	3.44	0.32
Эзэмшигчийн өмчийн дүн (тэрбум төгрөг)	8.3	8.4
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	1.00	2.52
Үнэ ашгийн харьцаа (P/E)	101.6	24.6
Үнэ эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B)	1.2	1.12
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	0.01	0.03
Эзэмшигчийн өмчийн өгөөж (ROE)	0.01	0.03
Нэгж хувьцааны ногдол ашиг (DPS)	0.01	-
Ногдол ашгийн өгөөж	1.25	-
Дундаж хувьцааны үнэ (төгрөг)	102.07	94.82
Дундаж зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	10.21	9.48

Эх сурвалж: Стандарт инвестмент ХХК

2008 оны I хагасаас 2012 оны II хагас хүртэл JTB хувьцаа нь байнга Топ-20 индексийн багцад байв.

Судалгааг хийсэн:

Цэдэвдорж ЧИМГЭЭ,
Судалгааны багийн ахлагч
chimgee@standardinvestment.mn
Т +976 70114433
М +976 99066293

Бямбаа МӨНХТУЯА,
Судалгааны ажилтан
munkhtuya@standardinvestment.mn
Т +976 70114433
М +976 99027432

КОМПАНИЙН ТОЙМ

Танилцуулга

“Женко Тур Бюро” ХК нь 1997 оны 2-р сард “Баянгол зочид буудал” ХК, “Женко” ӨО-өөс 2006 онд Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэн хойш жил бүр өсөх хурдтай ажиллаж, 2012 оны 9-р сард нийт 73 ажилтантай бөгөөд тэдний ихэнх нь “Баянгол Зочид буудал” ХК-аас хувьцаа авчирч, ажилладаг байна. 2012 оны 9-р сард нийт 73 ажилтантай бөгөөд тэдний ихэнх нь “Баянгол Зочид буудал” ХК-аас хувьцаа авчирч, ажилладаг байна.

Менежмент

“Женко Тур Бюро” ХК нь нийт 100,000,000 ширхэг энгийн хувьцаа гаргасан. Хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг. Хувьцаа эзэмшигчид болон хувьцааны эзэмшлийн бүтцийг дараах байдлаар харуулав.

Хувьцаа эзэмшигчид	Хувь %
Тур Бюро ХХК	20%
Мастер Фонд II	15%
Баянгол ЗБ ХК	11%
Д. Даваасүрэн	7%
Х. Баттулга	7%
“Firebird Mongolia” Фонд	6%
Бусад	35%


Компанийн удирдлагууд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга - С.Отгонбаяр


Гүйцэтгэх захирал - Б.Намуун

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Аялал жуулчлалын салбарын орлого, нийт жуулчдын тоо



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр Монголын хилээр гарсан дотоодын нийт зорчигчдын тоо 2007 оноос 2011 оны хооронд жил ирэх тусам нэмэгдсэн байна. Харин улсын хилээр орсон гадаадын жуулчин болон хилээр гарсан дотоодын жуулчдын тоо тухайн хугацаанд тогтвортой байжээ. Энэ салбарын ажилчдын сарын дундаж цалингийн хэмжээ 2007 онд 173,000 төгрөг байсан бол 2011 онд 341,000 төгрөг болж нэмэгдсэн байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээлснээр аялал жуулчлалын салбарын орлого 2009-2011 онд 213,341,491-282,687,977 ам.доллар буюу 288-381 тэрбум төгрөг болж өссөн байна. Цаашид шинээр баригдахаар төлөвлөгдөж буй нисэх онгоцны буудал ашиглалтанд орж, шинээр олон улсын нислэгүүд нэмэгдэх тусам Монгол улсыг зорих жуулчдын тоо өсөх боломжтой гэж үзэж байна.

КОМПАНИЙН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ

“Женко Тур Бюро” ХК нь жуулчны бааз, цогцолбор, гадаад дотоод аялал болон бусад туслах үйлчилгээг үзүүлж байна. 2007 оны 6-р сард “13-р зуун” цогцолборын үйл ажиллагааг эхлүүлсэн. 2008 оны 9-р сард “Чингис хаан” хөшөөт цогцолборын нээлтийг хийлээ. 2011 оноос Сингапур, Хятад, Япон, Тайланд, Солонгос, Бали болон Турк гэх мэт оронд гадаад аяллуудыг зохион байгуулж эхэлсэн бөгөөд, аяллуудын багцуудыг мөн нэмсэн байна. Тун удахгүй захиалагат нислэгийн үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа юм байна. 2012 оны 1-р сард “Чингис хаан” цогцолборт хоёр дахь музей болох Монголын эзэнт гүрний үеийн музейн нээлтийг хийж. Хөшөөт цогцолборын төлбөрийг гадаад дотоодын жуулчдад ижил болгон нэг хүний 7,000 төгрөг болгосон байна. 2009-2011 онуудад “Женко Тур Бюро” ХК-аар үйлчлүүлсэн нийт зочдын тоо өссөн байна. 2011 оны байдлаар “Чингис хаан” цогцолборт 105602, “13-р зуун” цогцолборт 8611, нийт 114213 зочин үйлчлүүлсэн байна. Цогцолборууд жуулчид хүлээн авах тал дээр аялал жуулчлалын 80-90 гаруй компанитай гэрээ байгуулан ажиллажээ. 2011 онд “Женко Тур Бюро” ХК-ийн борлуулалтын орлого өмнөх оныхоос 77.3% өсч, 2.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд түүний 36.1 хувийг “Чингис хаан” цогцолбор, 11.1 хувийг “13-р зуун” цогцолбор, 26.9 хувийг гадаад аялал, 25.9 хувийг дотоод аяллын орлогоос тус тус бүрдүүлсэн. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг борлуулалт -ын орлогын 58 хувийг, үйл ажиллагааны зардал 33 хувийг, цэвэр ашиг 9 хувийг эзэлсэн байна.

“Женко Тур Бюро” ХК-ийн 2012 оны зорилтууд:

- Үйлчилгээний шинэ төрөл, гадаад дотоод шинэ аяллын багц нэмэгдүүлэх болон компанийн брэнд, нэр хүндийг өсгөх
- “Чингис хаан” цогцолбор болон 13-р зуун цогцолборуудын засвар
- Боловсон хүчний ажлын гүйцэтгэл, үнэлгээний журам ба урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх

ДҮГНЭЛТ

“Женко Тур Бюро” ХК-ийн цэвэр ашиг нь 2011 онд өмнөх оныхоос 2.5 дахин өссөн бол хувьцааны дундаж ханш буурсан байна. Үнэ ба ашгийн харьцаа (P/E) 2010 онд 101.63 байснаас 2011 онд 37.61 болж багассан нь сайн бөгөөд энэ нь цэвэр ашиг нэмэгдэж, компанийн зах зээлийн үнэлгээ буурсантай холбоотой. Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B) 2010 онд 1.22 байснаас 2011 онд 1.12 болж буурсан нь эзэмшигчийн өмч 1.2 хувиар нэмэгдэж, компанийн зах зээлийн үнэлгээ буурсантай мөн холбоотой. Хөрөнгийн өгөөж (ROA) нь 2010 онд 1%, 2011 онд 3% байгаа нь хангалтгүй юм. Үүний аялал жуулчлалын салбарт хамгийн ойр болох зочид буудлын салбараас Баянгол зочид буудал ХК-ийн ROA (10%-12%), Улаанбаатар зочид буудал ХК-ийн ROA-тай (18%,25%) харьцуулахад мөн бага байна. Энэ нь магадгүй менежментийн үр дүн бага байгааг харуулж байна. Эзэмшигчийн өмчийн өгөөж (ROE) 2010 онд 1%, 2011 онд 3% байжээ. Компанийн хувьцаа эзэмшигчдэдээ тараасан ногдол ашиг 2008 онд 1 төгрөг, 2009 онд 1.2 төгрөг, 2010 онд 1.25 төгрөг, 2011 онд 4.29 төгрөг байв. “Женко Тур Бюро” ХК нь одоогоор өндөр ашигтай ажиллахгүй байгаа хэдий ч аялал жуулчлалын салбарт байр сууриа олсон, том компани гэж хэлж болох ба 2012 онд илүү их ашигтайгаар ажиллахыг зорьж байгаа юм.

Мэдэгдэл

YiyóꞤꞤ iyáyyéyē iú ylàð iyáyí zíyò oàànnūā oóààeààí àààð, oóààeààð nàíàe áópó ò°ò°íà° iðóóóeàeòúí ç°àe°à° àeø þí. Yíà aóðàñàí zíy òàíøééí iyáyy, áóñàà òííí iyáyyéyē, òàééààð çyðyá iú ç°àó°í oóòàéí iyáyyééééà áyèðayò zàééí ààéàeñà èèðayò á°à°à °°ð-e°àà°æ, oóàññàæ áíeíí /Ñòàíààðò Èíààñòíàíð ÕÕÈ °°ð-e°èòéà iyáyáayò àeàààzé/. Íyáyyééééà ç°àó°í ðàyàeàñàí oóàñ òzí áíeíí àeààí ààéàóóéèààúí òyðyáoyýíà çíðeóèñàí àà Ñòàíààðò Èíààñòíàíð ÕÕÈ-ééí ç°àø °°ð°èàzèáyýð iyáyyééééà ylàð iyáyí òyèáýðýýð oààø iú ààíæóóèàð, òzáyýð, oóóèààðeàòñà òíðeàéííí.

© 2012 Standard Investment LLC

ÒÀÉËÁÀĐ

[illegible]